



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2023 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 15-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр, Лхагва гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>1</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>2-3</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>4-13</i>
<hr/>	
<i>1.Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад зарцуулсан хөрөнгө, үр дүнгийн талаарх Үндэсний аудитын газрын тайланг сонсох</i>	<i>4-13</i>

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы
Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны
11 дүгээр сарын 15-ны өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны дарга Т.Энхтүвшин ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 16 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 68.8 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 21 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: А.Адъяасүрэн, Ц.Анандбазар, Т.Аубакир, С.Ганбаатар, Ж.Эрдэнэбат.

Хэлэлцэх асуудлын дараалалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням, Г.Ганболд нар Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад зарцуулсан хөрөнгө, үр дүнгийн талаарх Үндэсний аудитын газрын тайланг Тавантолгой-Гашуунсухайт буюу Тавантолгой-Зүүнбаян гэсэн чиглэл тус бүрээр сонсьё гэсэн горимын санал гаргав.

Горимын саналыг Байнгын хорооны гишүүд дэмжиж, аудитын тайланг чиглэл тус бүрээр сонсохоор тогтов.

Нэг.Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад зарцуулсан хөрөнгө, үр дүнгийн талаарх Үндэсний аудитын газрын тайланг сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, мөн газрын Аудитын менежер Б.Саруул, ахлах аудитор Б.Батдэлгэр, Г.Жавхлан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Гандулам, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Бүтээн байгуулалтад зарцуулсан хөрөнгө, үр дүнгийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг танилцуулав.

Байнгын хорооны дарга Т.Энхтүвшин Монголын төмөр зам Төрийн өмчит хувьцаат компани, Тавантолгой төмөр зам хувьцаат компанийн холбогдох албан тушаалтнууд хуралд оролцоогүй тул хуралдааныг хойшлуулъя гэсэн горимын санал гаргав.

Т.Энхтүвшин: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 3

Бүгд: 11

72.0 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул хуралдааныг хойшлуулав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 47 минут үргэлжилж, ирвэл зохих 16 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 68.8 хувийн ирцтэйгээр 11 цаг 08 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ҮЙЛДВЭРЖИЛГИЙН БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Т.ЭНХТҮВШИН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр,
Лхагва гараг Төрийн ордон “Их засаг”
танхим 10 цаг 21 минут.

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Т.Энхтүвшин: Эрхэм байнгын хорооны гишүүдийн энэ өдрийн мэндийг хүргэж байна.

Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа гишүүдээ та бүхэндээ танилцуулъя.

Батжаргал гишүүн ирсэн байна, Батлут гишүүн ирсэн байна, Бат-Эрдэнэ гишүүн ирсэн байна, Ганболд гишүүн ирсэн байна, Дамдинням гишүүн ирсэн байна, Наранбаатар гишүүн ирсэн байна, Туваан гишүүн байна уу, Тэмүүлэн гишүүн ирсэн байна, Цогтгэрэл гишүүн ирсэн байна, Энхтүвшин гишүүн ирсэн байна гээд.

Хуралд 68.8 хувийн ирцтэй байгаа учир хуралдаанаа эхэлснийг мэдэгдье ээ.

Байнгын хорооны гишүүдийн олонх нь хүрэлцэн ирж байнгын хорооны ирц 68.8 хувьтай бүрдсэн тулд Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдэж байна.

Байнгын хорооны хуралдааны хэлэлцэх асуудлыг та бүхэндээ танилцуулъя. Тавантолгой-Гашуун сухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад зарцуулсан хөрөнгө, үр дүнгийн талаарх Үндэсний аудитын газрын тайланг сонсоно.

Хэлэлцэх асуудалд дээр саналтай гишүүд байна уу? Дамдинням гишүүн. Дамдинням гишүүний микрофоныг өгөөрэй.

Г.Дамдинням: Гишүүддээ энэ өглөөний мэнд хүргэе ээ.

Тэгээд энэ бид нар чинь үндсэндээ ингээд 2 дахь жилдээ ороод нүүрсний хулгай гээд улс орон даяар яригдаж байгаа. Ер нь зууны л луйвар гэж ойлгогдож байгаа. Хэдэн их наядаар нь хулгай хийчихсэн хулгайн хамгийн том хулгай явж байгаа газар төмөр зам гэж яригдсан. Сүхбаатарын талбай дүүрэн ард иргэд жагсаж хулгай зэлгийн эсрэг тэмцээрэй гэж бид нарыг шахсан шаардсан.

Нүүрсний хулгайн сонсгол удахгүй яригдах байх. Нүүрсний хулгайн сонсголттой хамт энэ төмөр замтай холбоотой асуудлыг бид нар зайлигүй ярих ёстой. Энэ томоохон төмөр замууд дээр энэ аудитын орж ирж байгаа. Энэ дүгнэлтийг нь зүгээр л ингээд эхний хуудсыг нь сөхөөд харахад Тавантолгой Гашуун сухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг анх 950.7 тэрбум төгрөгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байсан 3 их наяд 653.7 тэрбум төгрөгөөр буюу 3.8 дахин их хөрөнгөөр хэрэгжүүлсэн ч хил холболтын төмөр замын ажил эхлэлийн шатандаа явагдаж байгаагаас одоогоор хил дамжуулан тээвэрлэлт хийх боломжгүй төмөр зам болсон байна аа.

Дараа нь Зэвсэгт хүчний анги нэгтгэлийг бүтээн байгуулалтын ажилд оролцуулах эрх зүйн зохицуулалт дутмаг зарим зохицуулагдаагүй харилцаанд үйл ажиллагаа явуулснаас хууль зөрчиж тодорхойгүй байдал үүсгэсэн байна гэх мэт энэ аудитын дүгнэлт ерөөсөө тэр чигтээ хууль зөрчсөн тухай асуудал яригдаж байна. Бидний өнөөдөр төрийн эрх барих дээд байгууллагад ажиллаж байгаа энэ цаг хугацаанд тохиолдож байгаа хамгийн том хулгай луйврыг бид нар ярих гэж байгаа Их хурлын дэгийн тухай хуулийн дагуу Төсвийн байнгын хорооноос аудитын сэдэв батлагдаад гараад энэ аудит хийгдсэн байгаа байх.

Энэ бол нүсэр том ажил болсон. Тэгээд энийг хэдүүлээ бол Дэгийн хуулиараа сонсоод өнгөрч болохгүй.

Тэгэхээр Байнгын хорооны дарга болон эрхэм гишүүдэд би ямар санал хүсэлт гаргамаар байгаа вэ гэхээр энд аудитын дүгнэлтийг дагаад Их Хурлаас ямар ажил хийх юм гэдэг нэг тогтоолын төсөл бид нар заавал оруулж ирэх хэрэгтэй байна. Хууль хяналтын байгууллагаар шалгуул. Засгийн газарт чиглэл өгсөн тэ? Тэгээд хугацаа өгөөд тэдний дотор Байнгын хороонд эргэж танилцуул олон нийтэд мэдэгд. Эсвэл хэдүүлээ ажлын хэсэг байгуулах юм уу эсвэл сонсгол явуулах юм уу зөвхөн төмөр замаар нь олон нийтийн сонсгол явуулах юм уу? Энэ тухай бид нар ярьж байж энэ асуудлыг нэг чигт нь гаргамаар байна. Түүнээс биш бид нар ингээд л Байнгын хорооны хурал дээр өнөөдөр энэ аудитын, энэ аймшигтай хулгай, луйврын, нүүрсний хулгайн хамгийн том хэсэг явж байгаа юмыг чимээгүй ингээд сонсоод өнгөрвөл маш утгагүй зүйл болно. Тэгээд би бол ямар хэлэлцэх асуудал дээр ямар санал гаргамаар байгаа вэ гэхээр энэ аудитын Тавантолгой-Гашиун сухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад зарцуулсан хөрөнгийн үр дүн гэсэн энэ аудитын том тайланг сонсьё.

Нэгдүгээрт энэ бол 1 дүгээр хэлэлцэх асуудал мэдээж төлөвлөснөөрөө орж ирье.

Хоёрдугаарт энэ тайланг дагаад гарах Байнгын хорооны шийдвэрийн төслийг ярилцъя гэсэн ийм 2 дахь хэлэлцэх асуудал оруулж ирэх саналтай байна.

Т.Энхтүвшин: Ганболд гишүүн.

Г.Ганболд: Сонсох нь зөв байх. Гэхдээ энэ өөрөө нөгөө нүсэр том асуудал учраас гурвууланг нь нэг асуудал болгож яримааргүй байх юм салгамаар байна. Ядаж дэгий хуулиар чинь бид нар 3, 4 минутад энэ 2-ыг чинь холихоор ерөөсөө

асуух асуулт хаанаа ч хүрэхгүй шүү дээ. Тийм ээ.

Тэгэхээр эхлээд Тавантолгой-Зүүнбаянгаа нэгд нь эхэлж ярьчихаад,

Хоёр дахь асуудал болгоод Тавантолгой-Зүүнбаянгаа. Ингээж ядаж салгаж яривал нэг арай жаахан ахиу бид нар мэдээлэл авах ийм боломж байгаа учраас хэлэлцэх асуудлаа дотор нь хуваагаад бүүр бараг тэр Гранд Тронтогийн аудит ч гэсэн ер нь дахиад нэг сэдэв болж болохоор л юм байгаа шүү дээ.

Гурав ч хувааж болохоор. Тэгээд ядаж нэг тэгж 2 хуваагаад сонсвол арай илүү гишүүд мэдээлэл авах боломж цаг хугацаа нэмэгдэх болов уу л гэсэн саналтай байна.

Т.Энхтүвшин: Ерөнхийд нь сонслоо. Тэгээд Дамдинням гишүүний бас гаргаж байгаа санал дээр санал бас нэгтэй байж байна. Ямар ч гэсэн энэ Тавантолгой-Гашиун сухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад зарцуулсан хөрөнгө үр дүнгээ өнөөдөр сонсож байя.

Тэгээд тогтоолын төсөл Засгийн газар руу бас чиглүүлсэн тогтоолын төсөл бас гаргах нь зөв байх гэдэг дээр санал нэг байж байна. Энэ гүйцэтгэлийн аудит дээр Тавантолгой-Гашиун сухайт, Тавантолгой-Зүүнбаян гээд хамтад нь үндсэндээ аудит хийгээд ороод ирсэн байгаа, тийм ээ. Тэгэхээр Дэгийн тухай хуулиараа нэг удаа л хэлэлцэхэд ийм дэгтэй юм байна. Тэгэхдээ эхлээд бол.

Хэлэлцэх асуудал дээрээ ингээж оруулъя тэгэх үү? Тийм болж байна болж байна.

Тэгвэл өнөөдөр асуудал дээр хэдүүлээ ингээд хуваачихъя тэгэх үү? Тавантолгой Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын зарцуулсан хөрөнгө, үр дүнгийн талаар хэлэлцье ээ.

Зүүнбаян-Тавантолгой гээд явчих уу? Тавантолгой-Гашуун сухайт гээд явчих уу?

Тэгвэл Тавантолгой - Гашуунсухайт, 1 дүгээр асуудал,

Хоёрдугаар асуудал, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын хөрөнгө, үр дүнгийн талаарх.

Гурав дахь асуудал.

Засгийн газарт чиглэл өгөх тогтоолын төсөл гээд.

Гурав дахь асуудал дээр дарга юу яаж болох уу? Тэгээд хэлэлцэх асуудал дээр Тавантолгой-Гашуун сухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын зарцуулсан хөрөнгө, үр дүнгийн талаарх Үндэсний аудитын газрын тайланг сонсох.

Гишүүд санал хэлж дууслаа.

Хэлэлцэх асуудалдаа орё? Хэлэлцэх асуудал дээр эхлээд яадаг шүү дээ.

Нэгдүгээр асуудал. Тавантолгой-Гашуунсухайт.

Хэлэлцэх асуудлаа баталъя хэдүүлээ. Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад зарцуулсан хөрөнгө, үр дүнгийн талаарх Үндэсний аудитын газрын тайланг сонсох.

Нэг дэх асуудал нь Тавантолгой-Гашуунсухайт.

Хоёр дахь асуудал нь бол Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад зарцуулсан хөрөнгө, үр дүнгийн талаарх Үндэсний аудитын газрын тайланг сонсох.

Гурав дахь асуудал нь бол тогтоолын төсөл батлах ажлын хэсэг байгуулах тухай, боловсруулах.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулж асуух асуулттай гишүүд байна уу? Алга байна.

Хэлэлцэх асуудлаа баталъя.

Санал хураалт.

Санал хураалтад оролцсон гишүүдийн 81.8 хувь нь дэмжсэн байна. Хэлэлцэх асуудал батлагдлаа.

Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2022 оны аудитын сэдэв батлах тухай 09 дүгээр тогтоолын дагуу Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад зарцуулсан хөрөнгө үр дүнгийн талаарх Үндэсний аудитын газраас гүйцэтгэлийн аудит хийж зөвлөмж гаргасан байж байгаа.

Төрийн аудитын тухай хуулийн 33.6-д Монгол Улсын ерөнхий аудитор нь энэ хуулийн 11, 12 дугаар зүйлд заасны дагуу гүйцэтгэлийн аудитын тайланг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороонд хүргүүлнэ гэж заасны дагуу Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад зарцуулсан хөрөнгө, үр дүнгийн талаарх Үндэсний аудитын газрын тайланг Улсын Их Хурлын Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороонд ирүүлсэн байна.

Үндэсний аудитын газрын тайланг Монгол Улсын Үндэсний Аудитын Ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг танилцуулна аа.

Дарга нь хөдөө томилолтоор ажиллаж байгаа. Ажлын хэсгийн 1 дүгээр микрофон.

Наранчимэг дарга сая хэлсэн юмыг ойлгосон биз дээ тийм ээ.

Эхлээд юу гэдэг юм Тавантолгой-Гашуунсухайтын чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалт, зарцуулсан хөрөнгө, үр дүнгийн талаар тайлангаа тавих нь байна шүү дээ.

Ц.Наранчимэг: Байнгын хорооны дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүн та бүхний энэ өдрийн амрыг эрвэ.

Үндэсний аудитын газраас Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад зарцуулсан хөрөнгө, үр дүн, аудитыг хийж гүйцэтгэсэн. Холбогдох байнгын хороодод 163 хуудас бүхий дэлгэрэнгүй тайланг хүргүүлсэн.

Мөн Байнгын хорооны гишүүд та бүхэнд 32 хуудас бүхий хураангуй тайланг хүргүүлсэн байгаа. Монгол Улсын ерөнхий аудиторын тушаалаар бид Улсын Их Хурал хэрэглэгчид, хэвлэл мэдээллийнхэн, олон нийтэд зориулж хураангуй тайланг бэлтгэдэг болсон. Энэ хураангуй тайлангаа *open audit.mn* сайтад тавьж мэдээллийг бүх холбогдох хэрэглэгч, сонирхогчид хүргэдэг ийм болсон байгаа.

Бид та бүхэнд энэ тайлантай холбоотой мэдээллийг бэлтгэсэн. Уг нь 32 слайд бүхий мэдээллийг бэлтгэсэн. Тэгэхдээ би товчлоод хураангуй тайлан тараасан учраас гол гол асуудлуудыг та бүхэнд танилцуулъя гэж бид бодож байна. Гүйцэтгэлийн аудитаар бид ерөнхий аудитынхаа дүгнэлтийг төмөр замуудын төслийг цогц байдлаар төлөвлөөгүйгээс шалтгаалан ойрын хугацаанд ТЭЗҮ-д заасан үр ашгаа өгөхөөргүй мухар замууд болсон байна гэсэн тайлангийнхаа ерөнхий дүгнэлтийг ингээж өгсөн байгаа.

Тайлан маань 3 бүлэгтэй. 3 бүлэг болгонд ерөнхий дүгнэлт, дотор нь холбогдох асуудлуудыг танилцуулсан байгаа. Тайландаа бид бодлого эрх зүйн талаар яг энэ төмөр замтай холбоотой

ямар бодлого эрх зүй байгаад байгаа юм? Тавантолгой төмөр зам чиглэлтэй холбоотой ямар ажлын хэсгүүд хэрхэн ажилласан юм? Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замтай холбоотой арга хэмжээг хэрэгжүүлэхийг Улсын Их Хурлаас гаргаж даалгасан тогтоолын төслүүдийг тайланд бас дурдаж өгсөн байгаа.

Нэгдүгээр бүлэг дээрээ бид төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогыг олон улсын стандартад нийцүүлэн шинэчлэн боловсруулах шаардлагатай байна гэж бодлогын арга хэмжээний хүрээндээ бол ингэж дүгнэсэн. Улсын Их Хурлын 2010 оны 32 дугаар тогтоолоор баталсан Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогод шинээр нийт 7900 орчим километр төмөр замыг 3 үе шаттайгаар барихаар төлөвлөсөн байгаа.

Нэгдүгээр үе шат нь 1100 км төмөр зам буюу Даланзадгад-Тавантолгой, Цагаан суварга-Зүүнбаян гэсэн 400км. Энийг бол бид аудитад хамруулсан. Сайнишанд-Баруун-Урт 350 км, Баруун-Урт-Хөөт 140 км Хөөт-Чойбалсан 150 км төмөр замууд аудитад хамрагдаагүй ээ.

Хоёрдугаар үе шатад 3200 км төмөр зам барихаар байгаа. Энэ дээр Арц суурьт, Нарийн сухайт, Шивээ хүрэн, 1255 км, Тавантолгой-Гашуунсухайт 267 км төмөр замын асуудал бол энэхүү тайланд хамрагдсан. Хөөт-Тамсагбулаг-Нөмрөг 380 км, Хөөт-Бичигт 200 км, Зүүнбаян-Ханги 280 км, Эрдэнэт-Арц суурь, 780 км гэсэн ийм 2 дугаар үе шатанд хэрэгжихээр эдгээр төмөр замууд тайланд хамрагдаагүй байгаа.

Гуравдугаар үе шатанд барьж эхлэхээр 3600 км төмөр зам байгаа. Баруун чиглэлийн төмөр зам ирээдүйд баригдах бусад болон Цагаан нуур зэрэг боомтоор дамжсан төмөр замын хөндлөн чиглэл, баруун босоо тэнхлэг

Тавантолгой-Гашуун сухайт, Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлээр экспортод гаргах авто зам барих, Улаанбаатар-Хархорин чиглэлд төмөр зам барих гэсэн ийм 3 үе шаттай төмөр замыг баримтлахаар бодлогод баримтлах бодлогод тусгасан байна.

Дунд хугацааны бодлогын баримт бичиг, хөгжлийн урт хугацааны бодлогын баримт бичгүүдийг Улсын Их Хурал, Засгийн газраас баталсан байгаа.

Дунд хугацааны бодлогын баримт бичигт бол төмөр замуудын чиглэл, нэршил, өртөг хэрэгжүүлэх хугацааг бол өөр өөрөөр илэрхийлсэн байна гэж аудитаар гарсан. Бүтээн байгуулалтын хэрэгжүүлэх хугацаа үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлтийг боловсруулаагүй байна энэ бол дунд хугацааны бодлогын баримт бичиг.

Хөгжлийн урт хугацааны бодлогын би баримт бичигт Дэлхийн улс орнуудын 60 орчим хувь нь ердийн буюу 1435 км цагариг ашигладаг бол манай улсын төмөр зам бодлогодоо 1520 мм байхаар тусгахаар хэрэгжүүлсэн байна.

Төслийн эрэлт хэрэгцээтэй уялдуулан судалгааны үр дүнд үндэслэн нэгдсэн бодлогын хүрээнд эрэмбэ дараатай төлөвлөөгүй байна гэдгийг хөгжлийн баримт бичиг байна гэдгийг аудитаар гаргаж ирсэн. Энэ бодлогын баримт бичгүүдээс Тавантолгой-Зүүнбаян, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэсэн бодлогын хэрэгжилтийг үнэлэхдээ алдагдсан боломж, үр дүнг бол энэ 10 нөхцөл байдлаар тооцоогүй байна гэдгийг гаргасан.

Нэгдүгээрт нь Хөгжлийн банкны зээлээр санхүүжүүлсэн бөгөөд хүүгийн зардалд 71.4 сая төгрөгийг үргүй зарцуулсан байна гэж ингэж байна.

Макс айнд буюу энд компанийн 2011 онд 1.3 сая ам доллароор боловсруулсан ТЭЗҮ-г ашиглаагүй бас үргүй зардал бий болгосон байна. Мон Цахир ХК 2014 онд 263.8 сая төгрөгөөр боловсруулсан цахилгаан эрчим хүчний зураг төслийг ашиглаагүй, бас үргүй зардал. Энэ бол бас үргүй зардал гарсан байна.

Бүтээн байгуулалтын ажил эхлэхээс өмнөх хугацаанд хийсэн далангийн ажилд захиалагчийн хяналтыг нормчилсноос илүүгээр зарцуулсан. Уг төсвөөр хилийн хяналтын бүс хүртэл төмөр зам тавьсан боловч холболтын төмөр замын ажил эхлээгүйгээс мухар төмөр зам болсон. Хил холболтын зураг төслийг бол боловсруулсан байна. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн 414.6 км төмөр зам барих ажил хийгдсэн ч үйл ажиллагаа нь бол аудит хийгдэх хугацаа нь жигдрээгүй байна. Европын холбооны шийдвэрээр 2050 он гэхэд дотоод шаталтын хөдөлгүүрийг зах зээлээс бүрэн гаргана гэж шийдвэрлэсэн байхад ТЭЗҮ-д дотоод шаталтын хөдөлгүүр бүхий зүтгүүрүүд ашиглахаар төлөвлөж худалдан авалтыг хийсэн байна. Гранд Тронте аудитын компанийн хийсэн аудитаар хүлээн зөвшөөрөөгүй зардлыг хэн хариуцах нь тодорхойлоогүй илүү Монголын төмөр зам ХК-ийн бүртгэсэн дүнгээс ам.доллароор илүү илэрхийлэгдсэн байна гэж аудитаар хөндлөнгийн олон улсын компанийн хийсэн аудитаар баталгаажуулсан байгаа.

26 сая 998.3 сая амдолларын суурь бүтцийн ажлын эвдрэл гэмтлийг засварлах ажлын зардлыг гэрээт ажлын дүнд бол оруулан тооцсон байна гэсэн ийм асуудлыг илрүүлсэн. Тавантолгой-Гашуун сухайт, Тавантолгой төмөр зам чиглэлийн төмөр замыг тээх нэвтрүүлэх хүчин чадлыг дамжин өнгөрөх өртөөд хилийн боомтын хүчин чадалтай нийцүүлэн төлөвлөөгүй байна аа.

Т.Энхтүвшин: Наранчимэг дарга аа сая бид нар Байнгын хороогоороо хэлэлцэх асуудлаа баталчихсан.

Тэгээд эхний асуудал дээр нь энэ Тавантолгой-Гашуун сухайтын төмөр замын бүтээн байгуулалтад зарцуулсан хөрөнгө үр дүнгийн талаар л яриадах даа.

Тавантолгой-Зүүнбаянгаа дараа нь ярья за юу. Бид нар хэлэлцэх асуудлаа баталчихлаа шүү дээ. Эхний асуудал Тавантолгой- Гашуун сухайтын төмөр замын үр дүнгийн талаар сонсьё гээд.

Хоёр дахь асуудал нь энэ Тавантолгой-Зүүнбаян гээд яриад байж байна.

Ц.Наранчимэг: Тайлан маань нэг гарчихсан учраас. Бүлэг 3-аас эхэлчихье тэгвэл. Тийм нэг сэдэвтэй нэг тайлан.

Т.Энхтүвшин: Хамтад нь явчих.

Ц.Наранчимэг: Эхний асуудал. 3 дугаар бүлгээсээ ярьчихвал болно л доо эхний асуудал.

Т.Энхтүвшин: Уг нь ингээд тус тусад нь ярь гээд би сая хэллээ шүү дээ. Сая Үйлдвэржилтийн байнгын хороо сая хуралдаад хэлэлцэх асуудлаа ингээд 3 чиглэл болгоод хэлэлцье ээ гээд.

Тавантолгой-Гашуун сухайтай л яриадахъя.

Ц.Наранчимэг: Тайлангийн 3 дугаар бүлэг дээр бид төрийн захиргааны байгууллагууд Тавантолгой-Гашуун сухайт чиглэлийн төмөр замын төслийн ерөнхий гүйцэтгэгчийг сонгох ажлыг хэлбэр төдий зохион байгуулсан байна гэсэн 3 дугаар бүлгийнхээ дүгнэлтийг өгсөн байгаа.

Засгийн газрын 2019 оны 304 дүгээр тогтоолоор Тавантолгой Гашуун сухайт чиглэлийн төмөр замын суурь бүтцийн барилгын ажлыг 2019 оны 8

сарын 15-ны өдрөөс буюу тогтоол гарсан өдрөөс хойш 2016 онд багтаан эхлүүлэхийг холбогдох яамдууд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын хамтарсан тушаалаар ерөнхий гүйцэтгэгчийг 5 хоногийн дотор сонгон шалгаруулахаар заасан зэргээс харахад төрийн захиргааны байгууллагууд гүйцэтгэгчийг сонгох ажлыг хэлбэр төдий шийдвэрийг гаргасан байна гэж ингэж үзсэн.

Гүйцэтгэгчийг элчит тэрэг нийлүүлэх хугацаа давтагдашгүй хүчин зүйлийн улмаас хойш л захиалагчид элчит тэрэг төлбөртэйг ашиглуулж байна гэж ингэж байгаа. Тавантолгой төмөр зам компани буюу Бодь интернэйшл компанийн хооронд байгуулсан Тавантолгой-Гашуун сухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын зураг төсөл худалдан авалт, барилгын ажлыг гүйцэтгэх гэрээний тусгай нөхцөл 8.7-д хугацаа хэтэрсний хохирол гэрээний ерөнхий нөхцөлийн энэ хэсгийг хэрэглэхгүй гэж заасан нь захиалагчтай алданги тооцох боломжгүй болгосон ийм гэрээ байгуулсан байна.

Тавантолгой нүүрс ачих ложистикийн төвийн ТЭЗҮ боловсруулах гүйцэтгэгчийг хэрхэн сонгосон нь тодорхойгүй. Боловсруулсан ТЭЗҮ-г хуульд заасны дагуу баталгаажуулаагүй байна. Тавантолгой-Гашуун сухайт, Тавантолгой- Зүүнбаян чиглэлийн төмөр замыг холбох төмөр замын ажлыг байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийгээгүй гэрээ байгуулж гүйцэтгүүлсэн. Гашуун сухайт шилжүүлэн ачих терминалын ТЭЗҮ-д хийсэн магадлалын нэгдсэн дүгнэлтийг төмөр замын байгууламжийн зураг төслийн эксперт дангаар баталгаажуулсан.

Гүйцэтгэлийн баталгааг талууд хоорондоо өөрсдөө баталгаажуулж их хэмжээний урьдчилгаа төлбөрийг гүйцэтгэгчид баталгаажуулж олгосон. Энэ баталгаа нь ажил дууссан тухай мэдэгдэл гарснаас хойш 28 хоногийн

хугацаанд хүчинтэй байна гэх баталгааг 2019 оны 10 дугаар сарын 17-ны өдөр Бодь интернэйшнл компанийн гүйцэтгэх захирал, Тавантолгой компанийн гүйцэтгэх захирал нар гаргаж тэр өдрөө талууд бол баталгаажуулсан байгаа.

Тавантолгой Гашуун сухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын зураг төсөл худалдан авалт барилгын ажлын захиалагчийн хянасан гүйцэтгэл 787.1 сая ам доллар буюу 78.3 хувь, санхүүжилтийн гүйцэтгэл 785.3 сая ам.доллар буюу 78.1 хувийн гүйцэтгэлтэй байна. Энийг Бодь интернэйшнл компани нүүрсээр олгох, олгосон санхүүжилтийн хугацааны дарааллыг бид графикаар харуулсан байна аа. Хил орчмын төмөр замын зурвас газрын эзэмшлийг хуульд нийцүүлэн шийдвэрлүүлэх шаардлагатай байгааг аудитаар бас дурдсан. Тавантолгой-Гашуун сухайт чиглэлийн төмөр замын төслийн бүтээн байгуулалтын явцад түгээмэл тархацтай ашигт малтмалын 107 ордыг ашиглахаар төлөвлөснөөс Улсын Их Хурлын 1996 оны 43 дугаар тогтоолоор улсын тусгай хамгаалалтад авсан говийн Бага дархан цаазат газрын нутагт нэг зөвшөөрөлгүй ашиглаж тусгай хамгаалалттай газарт Гашуун сухайт өртөө зүтгүүр эргэх тойрогт иилжүүлэн ачих терминал зэрэг байгууламж баригдсан байна Тавантолгой - Гашуун сухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажилд улсын болон техникийн комиссоос өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт бүрэн хангагдаагүй байсан.

Төрөөс төмөр замын талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх хугацаа санхүүжилтийн эх үүсвэр тодорхойгүй, хэрэгжилтэд оролцогч талуудын эрх үүргийг тодорхойлоогүй, хэрэгжилтийг бодитой үнэлээгүй, хэрэгжилтийг хангах холбогдох арга хэмжээг авч ажиллаагүйгээс хэрэгжилт хангалтгүй байгаа.

Тэгэхээр бид нарын саяын нөгөө 3 дугаар бүлэг дээр Гашуун сухайт төмөр замтай холбоотой асуудлаа танилцуулсан.

Одоо ерөнхий дүгнэлт рүүгээ орох гэж байгаа учраас ерөнхий дүгнэлтээ нэгдсэн 2 асуудлаа танилцуулж байж танилцуулах уу? Одоо танилцуулчих уу?

Т.Энхтүвшин: Танилцуулаад явчих.

Ц.Наранчимэг: Танилцуулж байгаа. Энэ хийсэн Тавантолгой-Гашуун сухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад зарцуулсан хөрөнгө үр дүнд аудитын байгууллагаас дараах дүгнэлтүүдийг өгсөн. Энэ дээр төмөр замын салбарын хэмжээнд бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх шийдвэрүүд удаа дараалан гарч байсан ч хэрэгжүүлэх төслүүдийг эдийн засаг нийгэмд үзүүлэх үр нөлөөгөөр нь эрэмбэлж цогц байдлаар төлөвлөөгүйгээс их хэмжээний үргүй зардал гарчээ. Гарсан байна.

Тавантолгой чиглэлийн төмөр замаар цааш дамжуулах өртөөдийн тээх нэвтрүүлэх хүчин чадал, тээвэрлэлт хийх хөдлөх бүрэлдэхүүн хүрэлцээгүйгээс суурилагдсан хүчин чадлынхаа 18.6 хувийг ашиглахаар Тавантолгой-Гашуун сухайт чиглэлийн төмөр замын хувьд хил холболтын цэгийг урьдчилан тохиролцоогүйгээс төмөр замаар хил дамжуулан тээвэрлэлт хийх боломжгүй зам болсон байна. Тавантолгой-Зүүнбаян, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын I км-т ноогдох өртөг ялгаатай байгаа нь замуудын зэрэглэл өөр, өртгийг бүрдүүлэх хөдөлмөрийн хөлс түүхий эдийн үнэ чанар харилцан адилгүй байсантай холбоотой байна.

Тавантолгой-Зүүнбаян, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг дотоодын хөрөнгө оруулалтаар амжилттай хэрэгжүүлсэн зарим үйл

ажиллагааны эрх зүйн зохицуулалт дутмаг нууцлалын зэрэглэлд хамаарч байсан шалтгаанаар холбогдох хууль зөрчсөн, үргүй зардал гаргасан, зориулалт бусаар зарцуулсан зөрчил илэрсэн нь залилангийн эрсдэл өндөр байх магадлалтай байна.

Тавантолгой-Зүүнбаян, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын төслүүдийн ажлуудыг бүрэн дуусаагүй, төлөвлөгдөөгүй нэмэлт ажлаас санхүүжилтийн хэрэгцээ нэмэгдэж суурь бүтэц эзэмшигч Монголын төмөр зам Тавантолгой төмөр зам компаниуд төлөвлөсөн арга хэмжээний орлого олох боломжгүй болж их хэмжээний өр төлбөр дамжуулан зээлийн эргэн төлөлт хойшлогдсон байна. Хөрөнгө оруулагч Эрдэнэс Тавантолгой компанийн хувьд 2 төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг 100 хувь санхүүжүүлж Тавантолгой төмөр зам, Зүүнбаян төмөр замд хувь хэм эзэмшлээсээ илүү хөрөнгө оруулсан. Зүүнбаян төмөр зам компанийг татан буулгаж Монголын төмөр зам ТӨХК-д нэгтгэсэн санхүүжүүлэх хөрөнгийн хэмжээ жил бүр нэмэгдэж, оруулсан хөрөнгөд үнэлгээ хийгээгүй, үр ашиг хүртэх боломжгүй Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад оруулсан 566.1 тэрбум төгрөгийн хөрөнгийг хэрхэх талаар шийдвэрт хүрээгүй зэрэг нь компанийн хувьцаа эзэмшигчдийн эрх ашигт нийцэхгүй байна. Төмөр замын доод бүтцэд ашигласан түгээмэл тархацтай ашигт малтмалын нэг шоо метрт ноогдох төлбөрийг сумдын ИТХ-ын тогтоолоор Тавантолгой-Зүүнбаян чиглэлд нэг төгрөг, Тавантолгой-Гашуун сухайт чиглэлд 125 төгрөгөөр буюу харилцан адилгүй тогтоож орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг бууруулсан байна.

Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын ажлын талаар танилцуулъя.

Төмөр замын байгууламжийн зураг төсөл төсвийг боловсруулж эрх бүхий байгууллагууд баталгаажуулсан ч.

Ингээд энийгээ тэгвэл орхичхоод цаашаа явчих уу? Нөгөө бид нар мэдээллээ нэг бэлтгэчихсэн учраас нөгөө 2 салга гээгүй учраас.

Т.Энхтүвшин: Гашуун Сухайт-Тавантолгой гоо л яриадахъя.

Гашуун сухайт.

Ц.Наранчимэг: Гашуун сухайтын дүгнэлтээр.

Тавантолгой Гашуун сухайт чиглэлийн төмөр замын төслүүдийг гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа ил тод өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтлаагүй. Төслүүдийн ТЭЗҮ-д заасан дүнгээр бидний гэрээг дотоодын зах зээлийн нэгж хооронд байгуулсан ч гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийн заалтууд Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжид нийцээгүй, харилцан ашигтай байхаар тохиролцоогүй байна.

Тавантолгой Гашуунсухайт өртөөдийн ажилтан албан хаагчдын амьдрах суурьшлын бүс байгуулах 45 сая ам.долларыг Гашуунсухайт өртөөнд баригдах шилжүүлэн ачих терминалын бүтээн байгуулалтад зарцуулснаар орон сууц барих хөрөнгийн эх үүсвэргүй болжээ.

Нүүрс ачих ложистикийн төвийн ТЭЗҮ-ийг хууль журамд нийцүүлэн баталгаажуулаагүй, Тавантолгой-Гашуун сухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замыг холбох төмөр замын төслийн байгаль орчны нөлөөллийн үнэлгээг хийгээгүй байхад гэрээ байгуулж гүйцэтгүүлсэн байна аа. Гашуун сухайт-Ганц мод хил дамнасан төмөр замын холболтын ажлын ТЭЗҮ зураг төслийг боловсруулаагүйгээс Тавантолгой-

Гашуун сухайт чиглэлийн төмөр замын төсөл ойрын хугацаанд эдийн засаг нийгмийн төсөлд эерэг нөлөө үзүүлэхээргүй байна гэсэн дүгнэлтийг өгсөн байгаа. Тавантолгой төмөр зам компанийн удирдах албан тушаалтан нь эрх мэдлээ хэтрүүлэн ашиглаж 3 дахь этгээдийн баталгаагүйгээр их хэмжээний урьдчилгаа төлбөрийг гүйцэтгэгчид олгосон байна.

Засгийн газраас Тавантолгой-Гашуун сухайт чиглэлийн төмөр замын бүтцийг барьж байгуулахад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг ТЭЗҮ-д заасан дүнгээр нүүрс урьдчилан борлуулах замаар болон бусад эх үүсвэрээр санхүүжүүлэхээр ишидвэрлэснээр Эрдэнэс Тавантолгой компанийн 2022 оны жилийн эцсийн байдлаар олгосон 8.1 сая тонн нүүрсийг өрсөлдөөний журмаар борлуулах биш хөнгөлөлттэй нөхцөлөөр санхүүжилтэд олгосноос ойролцоогоор 57.4 сая төгрөгийн ам.долларын орлого олох боломжийг алдсан байна. Тавантолгой-Гашуун сухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалт хийгдэх талбайн 471 га нь улсын хилийн зурвас, 495 га нь улсын тусгай хамгаалалтын говийн бага Дархан цаазат газарт хамаарч байхад холбогдох байгууллагаар ишидвэр гаргуулалгүй бүтээн байгуулалтын үйл ажиллагаа явуулсан байна.

Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийн ажил гүйцэтгэх гэрээ санхүүжүүлэх гэрээг тусад нь болон байгуулсан ажил гүйцэтгэл удааширсан, санхүүжилтийн гэрээнд төлбөрийг нүүрсээр 60 сарын хугацаанд ижил хэмжээгээр барагдуулахаар байсныг өөрчилсөн зэргээс Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажил гүйцэтгэлээс 56.6 тэрбум төгрөгийн илүү санхүүжилт олгосон байна гэсэн ийм дүгнэлтүүдийг өгсөн байгаа.

Т.Энхтүвшин: Тайлан дууссан уу? Хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийг танилцуулъя.

Д.Энхболд Гүйцэтгэл-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Б.Саруул Аудитын менежер, Б.Батдэлгэр ахлах аудитор, Г.Жавхлан ахлах аудитор, Тавантолгой төмөр зам Н.Будбаяр Гүйцэтгэх захирал байна уу? Б.Болор-Эрдэнэ Төсөл хөгжлийн газрын дарга байхгүй юу? Л.Мөнгөнчимэг Төлөвлөлтийн хэлтсийн дарга, Монголын төмөр зам Б.Отгонсүх Гүйцэтгэх захирал, П.Амарцэцэг Ерөнхий нягтлан бодогч, М.Эрдэнэсайхан Хяналтын албаны дарга.

Тэгээд энэ байхгүй бол тэгээд яаж хэлэлцэх юм бэ наадах чинь. Энийг ер нь бүхэлд нь хойшлуулбал яасан юм бэ?

Горимын санал гаргая.

Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад зарцуулсан үгүй ээ тэгээд тэр хүмүүс нь алга байна шүү дээ гол хүмүүс нь. Гол нь энэ Монголын төмөр зам Тавантолгой төмөр замаас л асуух юм байгаа биз дээ. Бүтээн байгуулалтад зарцуулсан хөрөнгө үр дүнгийн талаарх аудитын тайланг түрүүн Байнгын хороогоор бид нар салгасан байж байгаа.

Тавантолгой-Гашуун сухайт гэж нэг хэлэлцье.

Тавантолгой-Зүүнбаян гэж нэг хэлэлцье гээд.

Тэгээд 3 дахь асуудал нь болохоор Засгийн газар руу чиглэл өгсөн тогтоолын төслийг ажлын хэсэг байгуулъя гээд. Ингэж баталсан байж байгаа. Тэгээд бүхэлд нь хойшлуулбал яасан юм бэ гээд. Энийг тэгээд ийм замбараагүй ингээд оролцож байгаа хүмүүс нь ч гэсэн ингээд идэвх санаачилга байхгүй.

Нөгөө ажлын хэсэг нь ирээгүй байдаг. Тэгээд хойшлуулъя гэсэн ийм горимын саналыг би гаргаж байна. Хойшлуулъя гэдэг дээр санал хураая.

Хойшлуулъя.

Санал хураалт.

Энэ асуудлаа 3 тасалж оруулж ир ээ Үндэсний аудитын газар. Түүрүүн хэллээ шүү дээ. Тавантолгой-Гашуунсухайт гээд нэг бүлэг оруулж ир.

Тавантолгой-Зүүнбаян гэж нэг оруулж ир. Тэгээд тогтоолын төслийг бэлдэж оруулж ир та хэд бэлдэж өгөөдөх.

Шийдвэрийнхээ төслийг оруулж оруулж ирнэ. Ажлын хэсгээ сайн яагаарай. Тэр Тавантолгой төмөр зам, Монголын төмөр зам.

Тавантолгойн-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад зарцуулсан хөрөнгө, үр дүнгийн талаарх Үндэсний аудитын газрын мэдээллийг сонслоо.

Тэгээд оролцох ажлын хэсэг хүрэлцэж ирээгүй учир бүхэлд нь хойшлууллаа.

Хуралдаан дууссаныг мэдэгдье. Айн мэдэхгүй ирээгүй байна шүү дээ айн.

11.08 цагт

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ П.МЯДАГМАА*